



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/482

Булган сум

**Тусгай зөвшөөрлийн тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1, 8.1 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл"-ийг шинээр олгох цэгийн нэрсийг хавсралтаар баталж, 5 жилийн хугацаатай олгосугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга нар, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т тус тус даалгасугай.

3.Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Г.Ганбаяр цагдаагийн дэд хурандаа), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Ц.Бүрэнтуяа), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010624

07 дугаар сарын 01 ны/ний өдрийн 1/42 дугаар захирамжийн хавсралт



**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС**

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Булган	“Анаг” ХХК	Ц.Цэрэндэжид	Амралтын газрын дэргэдэх ресторан	“Анаг тур”
2	Рашаант	“Мөнх цагаан хайрхан” ХХК	Ц.Уранчимэг	Хүнсний дэлгүүр	“Мөнх цагаан хайрхан”
3	Рашаант	“Натур тур” ХХК	Э.Туул	Жуулчны баазын дэргэдэх	“Хөгнө хан”
4	Хангал	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	И.Жаргалсайхан	Амралт, аялал жуулчлалын цогцолбор	“Сэлэнгэ-1” (Алтан тэгшийн ам)
5	Хангал	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	И.Жаргалсайхан	Амралт, аялал жуулчлалын цогцолбор	“Сэлэнгэ-2” (Алтан тэгшийн ам)
6	Хишиг-Өндөр	“Очирт Орон хайрхан Уул” ХХК	Х.Одонтунгалаг	Хүнсний дэлгүүр	“Эрдэнэ сан”
7	Хутаг-Өндөр	“Уньтын рашаан” ХХК	Б.Хадбаатар	Амралтын газрын дэргэдэх ресторан	“Их булаг”
8	Хутаг-Өндөр	“Түмэн сувдны хишиг” ХХК	Б.Эрдэнэсүвд	Хүнсний дэлгүүр	“Маргад”
	Нийт-8				